



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Барилга акталж, нийслэлийн өмчийн  
бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4.2-т заасныг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Багахангай дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн хуучин барилгыг буулгаж, шинээр барилга барих болсонтой холбогдуулан тус газрын баланст бүртгэлтэй, нийт 425,257,100.86 (дөрвөн зуун хорин таван сая хоёр зуун тавин долоон мянга нэг зуун төгрөг наян зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад дурдсан барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.


2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн  
54 дугаар тогтоолын хавсралт



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалта д орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Багахангай дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн барилга	1981	Багахангай дүүрэг 1 дүгээр хороо	425,257,100.86	7,033,092.40	358.224.008,46	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2022 оны 02-07-395/468 дугаар дүгнэлтийг үндэслэн барилгыг нурааж шинээр барилга барих
<b>НИЙТ ДҮН</b>				<b>425,257,100.86</b>	<b>67,033,092.40</b>	<b>358.224.008,46</b>	